



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар Д/185

Хэрлэн сум

“Үндэсний супер лиг-2024” сагсан бөмбөгийн тэмцээнд оролцоход хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.21 аймгийн “Үндэсний супер лиг-2024” сагсан бөмбөгийн тэмцээнд оролцох Хэнтий аймгийн эрэгтэй шигшээ баг тамирчдын ирүүлсэн албан хүсэлтийн дагуу эрхийн төлбөрийн зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ